

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-д

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал хүргүүлэх тухай

Мандал Даатгал ХК-ийн 2020 оны Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах ТУЗ-ийн тогтоол болон бусад баримт бичгийг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 20/267 тоот албан бичгээр хүргүүлсэн. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа COVID-19 цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон.

Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит бус хурлаар Мандал Даатгал ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр 17:00 цагаас цахим хэлбэрээр зохион байгуулах шийдвэр гарсан бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өөрчлөлт орсон материалыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсаргасан материал:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит Хурлын зар
2. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, баримт бичгийн жагсаалт
3. Санал авах хуудас

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЖАВХЛАН

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахим хэлбэрээр зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2 дах хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 7-р зүйлийн 7.8.1 дэх хэсэг, 8-р зүйлийн 8.13.3, 8.13.4 дэх хэсэг, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн 13-р зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 20/003 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг биечлэн хуралдуулахаар шийдвэрлэж байсантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Пүрэв гарагт 17:00 цагаас компанийн албан ёсны фэйсбүүк <https://www.facebook.com/mandaldaatgal/> хаягаар дамжуулан цахим хэлбэрээр зарлан хуралдуулахаар өөрчилсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.stock.mandal.mn сайтаар хэрэгжүүлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 20/003 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолд заасантай адил байхаар тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 20/003 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолд заасан аргаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой, хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №2-оор баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг Хавсралт №3-аар баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 00 цаг 00 минут хүртэл байна.
7. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт

- №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.
8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
 9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Өлзийбаяр овогтой Ганзоригийг томилсугай.
 10. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Балдан овогтой Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ